

## ХОРИО ЦЭЭР – АЙДАС - НҮГЭЛ

М. Гантуяа /доктор (PhD), профессор/  
Б. Долгор /магистрант/  
МУИС, Философи, шаши́н судлалын тэнхим

**Түлхүүр үгс:** Аман хууль, хорио цээр, табу, айдас, ёс зүй, ёс суртахуун, байгаль хамгаалал, хүнлэг сэтгэл, нүгэл, шашины дэг ёс

**Товч утга:** Хорио цээрийн ёс нь хүний сэтгэлзүйн үзэгдэл болох айдсаас үүссэн хэмээн үзэж болно. Ингэхдээ шашины ойлголтоор дамжуулан хүмүүст айдас төрүүлэх замаар хорио цээрийг даган биелүүлдэг, биелүүлэхээс өөр аргагүй болгоход хүргэдэг байна. Тухайлбал: Монгол хорио цээрийн ёсонд лус, савдаг хилэгнэнэ, тамд унана, буян хишиг харина, өөрийн чинь толгой дээр бууна, нүгэл болно гэх мэт шашины ойлголтуудыг ашиглан хүмүүсд айдас төрүүлэх замаар гаж буруу зүйлээс хол байх, ёс суртахууныг нь төлөвшүүлэх, ариун нандин зүйлийг хамгаалан уламжлуулдаг тухай асуудлыг энэхүү өгүүлэлд хөндсөн болно.

Үндэстэн бүхний онцлогт тохирсон хууль бүхний дээж тунхаг ҮНДСЭН ХУУЛЬ төрж гарахаас өмнө хэдэн мянган жилийн тэртээ хүмүүсийн харилцаа, ёс суртахууны хэм хэмжээг АМАН ХУУЛИАР зохицуулж байжээ. Аман хууль гэж ерөнхийлөн нэрлэж байгаа тэр хууль бол уг гарвалаараа ХОРИО ЦЭЭР гэсэн ойлголт болно. Түүнийг дэлхийн олон улсад түгсэн нэр томъёогоор нэрлэвээс ТАБУ хэмээнэ.

Табу буюу Хорио цээр нь полинез гаралтай үг бөгөөд монгол хэлнээ гэсгээгтүн, хөл хорих, цээрлэл, цээрлэх ёсон, хорио цээр гэх мэт хэлбэрээр тэмдэглэгдсэн байх боловч утгын хувьд ижил доорх үндсэн санааг агуулдаг. Үүнд:

Нэгд. Хорио цээр нь ариун нандин зүйлийг хамгаалж уламжлан хөгжүүлэх

зорилготой.

Хоёрт. Бузар, буруу, аюултай зүйлийг хаан хориглох, тэдгээрийг дадал зуршил болохоос урьдчилан сэргийлэхэд чиглэгддэг.

Хорио цээр буюу табу нь шашины ойлголтыг өөртөө агуулж байдаг бөгөөд хүний ямар нэг үйл хөдлөлийг далдын хүчний нөлөөгөөр явагддаг гэсэн итгэл үнэмшилд тулгуурладаг. Тэрхүү далдын хүчний нөлөөг сааруулах, эсвэл түүнээс хамгаалах зорилгоор тогтоосон шашины дэг ёс, зан заншлыг хорио цээр гэж үзэж болно. Хэрвээ тэрхүү цээр ёсыг зөрчвөл хувь хүнд, эсвэл гэр бүл, овог угсаа, улс үндэстэнд ч аюул занал учирна гэсэн айдас нь хорио цээрийг ягштал мөрдөх уламжлалыг бий болгожээ. Аажмаар хорио цээрийн уламжлалт ёс нь тухайн

ард түмний зан заншил, шашин шүтлэг, хууль ёс болж хувирсан байдаг.

Хорио цээрүүд бий болсон уг шалтгааныг нэг бүрчлэн тогтооход хэцүү боловч ихэнхи эрдэмтэн судлаачид анхдагч шалтгаан нь айдас хэмээн үзсэн байдаг. З.Фройд<sup>1</sup> хорио цээрийн жинхэнэ эх сурвалжууд нь онц эрх дархтай ангиудын эрх ашгийг бодвол хамаагүй гүнзгий байдаг, тухайлбал, чөтгөр шулмасын хүчнүүдийн үйлчлэлийн өмнө айн дагжих айдсаас үүсдэг хэмээсэн байдаг бол хэл шинжлэлч Л.Түдэв<sup>2</sup> бээр айдас нь хоригийг төрүүлсэн хэмээжээ. Харин Өвөр Монголын судлаач Соном тэргүүтэй эрдэмтэд хорио цээр үүссэн шалтгааныг ийнхүү тодорхойлжээ: хүн төрөлхтөний нялх үе, даруй байгалийг эрхшээгч хүчин чадал дорой, үйлдвэрлэлийн хүчин хөгжиж чадахгүй балар эртний нийгэмд хүмүүс байгалийн элдэв үзэгдэл ба олон аюул сүрдүүлэгт үргэлж өртдөг байна. Ийм учраас ид шидтэй онгон хэмээгдсэн ба бузар муухай хэмээгдсэн юманд шууд хандах, эсвэл түүний талаар шууд ярьж хэлхээс эрхбиш зайлсан гэдэг. Эс бөгөөс байгалийн хүчний шууд шийтгэлд учрах болно хэмээн итгэдэг улмаас цээр буй болжээ<sup>3</sup> хэмээн айдас болон итгэл бишрэлтэй холбон бичжээ. Эндээс дүгнэвэл хорио цээр (табу) болон шашин

үүсэх сэтгэлзүйн гол шалтгааныг айдас хэмээн үзэж болохоор байна.

Түүнчлэн хорио цээрийн ёс нь зайлшгүй мөрдөх ёстой дэг ёсыг бий болгосон байдаг бөгөөд яагаад тухайн үйлдлийг хийж болохгүй вэ гэсэн асуултанд тодорхой тайлбар өгөхөөсөө илүү хорио цээрийг зөрчвөл ямар үр дүн гарах вэ гэсэн асуултанд хариулсан байдаг. Хариулт нь ихэвчлэн ямар нэгэн далдын хүчний сөрөг нөлөө бий болно гэсэн шашины тайлбар байдаг бөгөөд энэ нь хүмүүст айдас төрүүлэх зорилготой ажээ. Иймээс “айдас” хэмээх сэтгэлийн үзэгдлийг тайлбарлах замаар хорио цээрийн утга учирьг авч үзэхийг оролдъё:

Ямар нэг хэцүү хүнд асуудал тулгарснаас үүдсэн сэтгэлийн мэдрэмжийг айдас гэнэ. Сэтгэл судлалд айдсыг аливаа сэтгэл хөдлөлийн үндэс гэж үзэх нь ч бий. Аливаа бэрхшээл зовлонгоос зайлсхийхэд энэ мэдрэмж урьдчилсан санамж болж өгдөгөөрөө тустай.

Гэхдээ айдас их хэмжээгээр төрөх нь өөртөө итгэх итгэлийг алдагдуулж, сэтгэлийн хямрал үүсэх шалтгаан болж болно.

Хүн өөрөө зохицуулж чадахгүй айдсыг, тухайлбал үхлээс айх айдсыг сэтгэл судлалд ихэвчлэн фобий гэж нэрлэдэг. Чухам энэ нь л хорио цээр болон шашины ойлголт үүсэх шалтгаан болсон байх магадлал өндөр байна. Айдсыг хорио цээр болон шашины үүднээс авч үзэхэд зөвхөн амьдрал үхлийн тухай асуудал төдийгүй ёс суртахууны асуудал холбогдоно. Ялангуяа үхлийг нөгөө ертөнц, хойд насанд очих зааг гэж итгэх

<sup>1</sup> Зигмунд Фройд (1856-1939) Австрийн мэдрэлийн эмч мөн алдарт сэтгэл судлаач юм. Психоанализын эцэг гэгддэг. Хүмүүсийн ухамсаргүй хийдэг үйлдлийг шинжлэх ухааны аргаар хамгийн анх судалснаараа сэтгэл судлалд томоохон байр суурь эзэлдэг. Хорио цээр ба онгон шүтлэг хэмээн Монгол хэлнээ 2010 онд хөрвүүлэгдсэн ном нь бидний судалгаатай тодорхой хэмжээгээр холбогдож байгаа болно.

<sup>2</sup> Лодонгийн Түдэв 1935 онд Говь-Алтай аймгийн Наран сумд төрсөн. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын Уран Зохиолч, СГЗ, Төрийн шагналт доктор, УБИС-ийн хүндэт профессор. Түүний аман хууль хэмээх ном нь бидний судалгааны ажилд томоохон түлхэц үзүүлсэн юм.

<sup>3</sup> Соном нар. 1991. Монгол цээрийн ёсон. 3 тал (Уйгаржин Монгол бичгээр бичигдсэн. 2000 гаруй Монгол цээрийг багтаасан толь)

тохиолдолд энэ амьдралдаа түүнд бэлтгэх, зөв амьдрах тухай асуудал өөрийн эрхгүй үүсдэг байна. Өөрөөр хэлбэл, энэ амьдралд үүсч байгаа айдас нь нөгөө ертөнц, хойд насанд санаа зовсон айдас болж хувирна. Чухам хойд насанд санаа тавьсан айдас л энэ насандаа зөв амьдрах ёс суртахууны хариуцлагыг хүмүүст төрүүлдэг байна.

Ийнхүү хойд насны тухай шашины ойлголтоор дамжуулж энэ насандаа ёс зүйтэй, хариуцлагатай амьдрах арга ухааныг заахдаа айдас төрүүлэх замаар ийм итгэл үнэмшлийг хүмүүсийн сэтгэлзүйд дадал зуршил болгохын тулд хорио цээр үүссэн гэж хэлж болно.

Английн эрдэмтэн С.Н.Той<sup>4</sup> “зан суртахууны хууль ёс тодорхой хэмжээгээр илрэх хэлбэрийг табу гэнэ” хэмээн тодорхойлсон байдаг.

Оросын сэтгэл судлаач эрдэмтэн Ю.В.Щербатых<sup>5</sup> айдсыг биологийн, нийгмийн экзистенциаль айдас гэж гурван зүйлд ангилжээ.

Түүний үзлээр: Хэн нэг хүний амьд явах эсэхийг шийдвэрлэхтэй холбоотой үүссэн айдсыг биологийн айдас гэнэ.

<sup>4</sup> Crawford Howell Toy (1836–1919) – Иудейн шашин судлаач. Виржинийн болон Берлиний Их сургуульд сурч байсан, АНУ-ын Умард Баптист Теологийн семинарт болон Харвардын Их сургуульд багшилж байсан. Түүний зохиолуудаас 1999 онд хэвлэгдсэн “A critical and Exegetical Commentary on the Book of Proverbs” бүтээл нь бидний судалгаанд ямар нэг хэмжээгээр холбогдсон юм.

<sup>5</sup> Юрий Викторович Щербатых – XX зууны сүүл, XXI зууны эхэн үед нэр нь алдаршиж байгаа Оросын эрдэмтэн, биологийн ухааны доктор. Тэрээр судалгааныхаа нэлээд өндөр түвшинд хүрсэн үедээ хүний амьдралд онцгой тохиолдсон үйл явдлаас үүсэн бий болох сэтгэл хөдлөлийн үзэгдэл, тухайлбал айдсыг психофизиологийн үүднээс судалж үзээд айдсын сэтгэлзүйг оношлох, хэмжих аргыг боловсруулсан байна. Тэрхүү судалгааных нь үр дүн орчин үеийн Оросын нэр хүнд бүхий “Психологический журнал”, “Журнал высшей нервной деятельности им. И.П.Павлова”, “Физиология человека” гэх зэрэг сэтгүүлдэд хэвлэгдээд байна.

Хүн нийгмийн байр сууриа алдахтай холбоотой үүссэн айдсыг нийгмийн айдас гэнэ. Хүний мөн чанартай холбоотой айдсыг экзистенциаль айдас гэнэ.

Хүн үхлийн ирмэгт тулахад амьдралынхаа мөн чанарыг тунгаан эргэцүүлдэг нь экзистенциаль айдас юм. Энэ үед өөртөө шүүмжлэлтэй хандаж, алдаагаа засахыг хүсэвч бүх юм оройтсон байдаг. Үүнийг ухаарах завч үгүй, хүсэлч үгүй амьдарч байх үед нь хүмүүст логик, рациональ тайлбараас илүү айдас төрүүлэх хорио цээрүүдийг дадал болгон хэвшүүлж уламжилжээ.

Эрт дээр үеэс эцэг өвгөдийн сургаал айлдвараар уламжилж ирсэн хорио цээрийг хойч үедээ үргэлжлүүлэн өвлүүлэх эсэх тухай ярихын өмнө нэгдүгээрт, хорио цээрийн ёсыг зөрчвөл бий болох далдын сөрөг хүчин үнэхээр байгаа юу, хоёрдугаарт, хорио цээрийг хэвшүүлэхийн тулд заавал айдас үүсгэх тайлбар байх албатай юу гэсэн асуудалд хариулт өгөх хэрэгтэй болж байгаа юм.

Эхний асуултанд хариулахын тулд хэдэн жишээ авъя:

1. Уулын нэрийг дэргэд нь хэлж болохгүй, уулын эзэн хилэгнэж хорлоно, иймээс “хайрхан” хэмээн хүндэтгэж ярих хэрэгтэй. Тэндээс хөрс шороо, чулуу хөдөлгөх, ургамал өвс, мод таслан авах, ан гөрөө хийхийг чандлан цээрлэдэг.

2. Гал руу хурц үзүүртэй мэс, бохир зүйлс, хар ус ойртуулахыг цээрлэнэ. Галын бурхан хилэгнэж гэр бүлд хорлол болно. Галаа өөх тос, архи сархадаар мялааж баярлуулж байх хэрэгтэй.

3. Рашаан усны дэргэдэх мод,

бургасыг огтлох, хад чулууг хөндөх хөдөлгөх, юм угаах, угаадас асгах, гадаалах, морь харахыг чанд цээрлэнэ. Зөрчвөөс ариун дагшин газрын ус бузартана, лус хилэгнэнэ.

4. Шувуу өндгөө дарж байхад үргээх, үүрийг нь эвдэхийг цээрлэнэ. Үл хэрэгсвээс шувууны хараал хүрч айл гэр шувууны бусниулсан үүр мэт болно.

Дээрхи хорио цээрүүдэд уулын эзэн, галын бурхан, лусын эзэн, шувууны хараал гэх мэт далдын хүчний талаархи шашины ойлголтууд уг үйлийг хийхгүй байхын гол шалтгаан нь болж байна. Логик тайлбар нь уул ус, гал хий, салхи шуурга, газар дэлхий, араатан амьтанг бүхэлд нь хамгаалах, хайрлах сэтгэл төрүүлэх зорилготой нь тодорхой байдаг. Гэвч “байгаль дэлхийгээ хайрлаарай, байгальтай буруу хатуу харьцвал өөрсдөд маань хортой үр дагавар гарна” гэж сургах, “байгаль дэлхий бол эзэн сахиустай учир түүнээс айх хэрэгтэй, эс бөгөөс хорлол болно” гэж сургах хоёрт ямар ялгаа байна вэ. Эхнийх нь учир шалтгааныг тайлбарлаж байгаа боловч “заавал ийм бай” гэсэн хатуу шаардлага тулгаагүй байна. Харин сүүлчийнх нь буюу шашины ойлголтоор айдас үүсгэх арга нь хүмүүсийг тухайн шаардлагыг заавал мөрдөх сэтгэлзүйн арга болж байна. Энэ нь хууль журмаас ямар ялгаатай байх вэ гэсэн бас нэг асуулт тавья. Хууль журам бол төрийн албадлага бөгөөд эс хэрэгжүүлбэл хуулийн бодит шийтгэл, цааз ял оногдоно. Харин хорио цээр нь шашины ойлголтоор тайлбарлаж байгаа гэдэг утгаараа нөгөө ертөнц, далд ертөнцийн тухай ойлголтоор айлгах ёс юм.

Үүнтэй холбоотойгоор монголчуудын хорио цээрийн ёсонд Буддын шашины ойлголт ихээр туссан байдаг. Үүний хамгийн түгээмэл ойлголт нь Буддын шашины “нүгэл” хэмээх ойлголт болно.

Буддын сургаал ёсоор “нүгэл” гэдэг нь “буруу үйл” гэсэн утгыг илэрхийлдэг бөгөөд нүгэл нь хойд насандаа доод төрлийг олох шалтгаан болно гэж үзнэ. Харин нүглийг эс хийх нь “буян” буюу “сайн үйл” болох ба хойд насандаа дээд төрлийг олох шалтгаан болно гэж үздэг. Хорио цээрийн ёс нь далдын ямар нэг зүйлээр айлгаж уг үйлдлийг хийлгэхгүй байх зорилго агуулдаг бол Буддын “нүгэл” хэмээх ойлголт нь “хойд нас” хэмээх энэ насандаа харж үл чадах далдын үр дагаврыг сануулж байгаагаараа хорио цээртэй төстэй юм. Тиймээс ч монголчууд нийтээрээ Буддын шашин шүтэх болсон цагаас хорио цээрийн ёсондоо “нүгэл” хэмээх Буддын шашины ойлголтыг хэрэглэсэн байх нь элбэг.

Буддын шашинд цээрлэж няцаасан их хэмжээний хорио цээр байх бөгөөд тэдгээрийг “арван хар нүгэл”-д хураангуйлдаг. Буддын шашины ёсоор хүн нүглийг бие, хэл, сэтгэлээрээ үйлдэх бөгөөд биеэр үйлдэх нүгэлд (амьтны амь таслах, хулгай хийх, буруу явдал), хэлээр үйлдэх нүгэлд (худал хэлэх, хов ярих, ширүүн үг, чалчаа үг), сэтгэлээр үйлдэх нүгэлд (хөмхөй сэтгэл, хорлох сэтгэл, буруу үзэл) зэрэг нь багтдаг<sup>6</sup>.

Одоо “нүгэл” гэсэн тайлбар бүхий монгол хорио цээрийн жишээ авч үзье:

1. Аав, ээжийнхээ өөдөөс хялайн

<sup>6</sup> Аръяасүрэн Ч, Нямбуу Х.1991. Монгол ёс заншлын дунд тайлбар толь, 17 дахь тал

харах, хэдэрлэх, хараал хэлэхийг цээрлэнэ. Зөрчвөөс амьтны амь бүрэлгэснээс дутуугүй нүгэл хилэнц болно. *Эрэгнээс төрж, элснээс ургасан биш тул эцэг эхээ хүндлэн асарч, үг сургаалыг нь сонсох, дагах, хүндлэх нь Монголчуудын эрхэм ёсон бөлгөө.*

2. Амьтны амийг зугаацан ёс бусаар таслах, ургамал цэцгийг хайр найргүй хөнөөхийг цээрлэнэ. Их нүгэл гэнэ. *Амьтны амь таслах нь Буддын шаашин дахь арван хар нүглийн нэг нь боловч цаад утгаараа ургамал, ан амьтныг хайрлан хамгаалах, байгалийн тэнцвэрийг алдагдуулахгүй байлгах гэсэн Монгол ухаан нуугдаж байна.*

3. Будаалганы аяганд савх хатгаж тавихыг цээрлэнэ. Нүгэл буюу муу ёр удлаа хэмээн<sup>7</sup>. *Цаазаар авах ялтанд өгөх хоолонд, эс бөгөөс үхсэн хүнд тахил тавихад тиинхүү савх хатгадаг ёс байжээ. Өөртөө болон ойр орчныхондоо мууг, үхэл дуудлаа хэмээн ихэд цээрлэдэг нь далдын ямар нэгэн хүч нөлөөнөөс айх айдсаас үүдэлтэй эртнээс уламжилж ирсэн цээр юм. Харин өнөө үед энэхүү цээр ёс нь мартагдаад байгаа нь тухайн ахуйтайгаа зөрчилдсөний илрэл юм.*

4. Ванчир (очир) хонх дамраар тоглож наадахыг цээрлэнэ. Хурал номын хэрэгсэл, бурхан тахилаар наадваас алдас, нүгэл болно гэнэ. *Монголчууд эрт үеэс ариун нандин гэсэн зүйлсээ дээш нь залдаг уламжлалтай нь нэг талаас хүндлэхийн учир, нөгөө талаас тухайн далдын хүч нөлөөг өөртөө агуулсан зүйлтэй буруу харьцаас гай барцад тохиолдоно хэмээн*

*итгэдгийх юм. Өнөө үед ч тухайн шаашин хийгээд далдын хүч нөлөөг агуулж буй объектыг шүтдэг ч бай шүтдэггүй ч хаа тааралдсан газраа дээш нь залдаг нь айж эмээснийх, хүндэлж үздэгийх болно.*

5. Гуйлгачин ядуу хүнийг ядуу хоосноор нь дайрч доромжлохыг цээрлэнэ. Урьд насны лай ланчиг, энэ насны үйлийн үрээр зовж яваа хүнийг дайрч доромжилвоос өөрийн чинь хар толгой дээр хожим тэрхүү зовлон бууна, ядарсан амьтныг гомдоох их нүгэл болно гэнэ. *Хүнийг хүн шиг үзэх, хүнлэг сэтгэлийг бий болгоход уг хорио цээрийн цаад утга оришиж байна.*

6. Цэргийн хүн бэртсэн, шархадсан нөхрөө орхин зайлахыг цээрлэнэ. Үл хэрэгсвээс гай гамшиг тохиолдох үес ганцаардана, тангараг тасарсантай адил нүгэл болно гэнэ. *Хүн хүнээ хайрлах хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй холбогдон гарсан хорио цээр хэмээн цаад утгыг нь ухан ойлгож болох юм. Эсвэл магадгүй дайн тулааны үед хамт тулалдаж буй цэрэг нь шархадсан үед хаяж явах асуудал ихээр гардаг байсан учраас тухайн хүний далдын хүчнээс айх айдас, өөрөө ийм байдалд орвол хэн нэгэн хаяад явбал яах вэ гэдэг айдас дээр нь тулгуурлан гарсан хорио цээр байж болох талтай.*

7. Ээжтэй хүүхэд энгэрээ зуудаггүй нүгэл<sup>8</sup>. *Энгэрээ зуувал ээжгүй болно нүгэл гэх нь хүүхдийн гаж буруу зурилыг арилгах гэсэн санаа юм. Бага балчир хүүхдэд энгэрээ зууж болдоггүй юмаа муухай, хувцас чинь хурдан урагдана гэж мянга хэлээд үгэнд ордоггүй. Түүний оронд нүгэл,*

<sup>7</sup> Нацагдорж Ц, Нямбуу Х.1993. Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь, 1 дэх тал

<sup>8</sup> Өлзийсайхан Ж.2001. Ардын сурган хүмүүжүүлэх зүйн зарим асуудал.13 дахь тал

яагаад гэвэл ээжгүй болно гэж хэлэхэд хүүхэд тухайн нүглийг дахин хийдэггүй байна. Энэ нь хийж болохгүй, болдоггүй юм гэж хий хоосноор сургаснаас давхар утгатай үр дүнтэй арга юм хэмээн ардын сурган хүмүүжүүлэх зүйд үздэг.

Эдгээр хорио цээрүүдийн цаад утга учир нь хүний ёс суртахууныг төлөвшүүлэх, хүнлэг энэрэнгүй сэтгэл суулгах, байгаль дэлхийтэйгээ зөв зохистой харьцах, ёс төртэй хүн болгоход чиглэгдсэн байх бөгөөд тухайн хорио цээрийг зөрчвөл НҮГЭЛ болно гэдэг шашины тайлбар өгч байна. Харин нүгэл гэж юу вэ? гэдэг асуултанд тодорхой тайлбар өгөөгүй байгаа бөгөөд нүглийг үйлдвээс лус хилэгнэнэ, сахиус хилэгнэнэ, эрдэм номгүй эргүү мунхаг болно, тамд унана, өөрийн чинь толгой дээр бууна, алдас болно, ээжгүй болно гэх мэт хүнд айдас төрүүлэх үг хэллэгийг ашигладаг байна.

Энэхүү айдас төрүүлэх үг хэллэгийн тусламжтайгаар тухайн хүнд нүглийг үйлдэхгүй байх дадал зуршил суудаг бөгөөд НҮГЭЛ гэж ямартай ч муу буруу, аюултай зүйл, нүглийг зөрчвөл өөрт болон бусад, хүрээлэн буй ертөнцөд аюул учрана гэдэг итгэл үнэмшил дээр тулгуурлан тухайн нүглийг дахин үйлдэхгүй хэвшдэг байна.

Тэгвэл байгаль хамгаалах, гэр бүл, гал голомтоо нандигнах, ёс суртахууныг нь төлөвшүүлэх зэрэг зөв заншлыг хэвшүүлэхийн тулд шашинаас ангид, шинжлэх ухаанч тайлбар өгч болохгүй юу гэсэн асуултанд хариулах замаар хоёр дахь асуудал руугаа орёе.

Гал руу гараа ойртуулж сониучирхах нялхбалчирхүүхдийг эцэг эх нь “иймангас” хэмээн айлгах замаар тухайн үйлдлийг дахин хийхгүй хэвшүүлэхийг оролддог. Учир нь энд логик тайлбар хүлээж авах чадвар хүүхдэд хараахан суугаагүй байна. Тэгвэл насанд хүрсэн хүмүүсийн тухайд ч тэр бүр логик учир шалтгааныг тайлбарлах боломжгүй, зөвхөн хорио цээрийн аргаар айдас үүсгэж тухайн үйлдлийг хийхийг хориглох тохиолдол олон байна. З.Фройд зохиол бүтээлдээ балар эртний хүмүүс цус ойртохоос сэргийлж дархлалын тогтолцоог бий болгохын тулд ах дүү нар хоорондоо бэлгийн харьцаанд орохгүй байх айдас төрүүлэм хорио цээр үүссэн тухай дурдсан байдаг<sup>9</sup>.

Одоо дараахь монгол хорио цээрүүдэд хэрхэн айдас үүсгэж уг үйлдлийг хийлгэхгүйгээр хорьж байгааг харъя:

1. Гутлаа чирч явахыг цээрлэнэ. Өвчинд баригдсан, насанд дарагдсан хүн хөлөө дааж ядан гутлаа чирдэг тул хийморьт муу гэнэ. *Гутлаа ариг гамтай өмсөх, цэвэр цэмцгэр явахыг сургаж буй цээр бөгөөд өвчин зовлонд баригдахыг зөгнөлөө, ингэж яваад байвал өвчин тусна гэдэг үйл хөдлөлийн ид шид, далдын хүчнээс айх айдас дээр нь тулгуурлан муу зуршилыг нь засаж буй хэрэг юм.*

2. Нялх хүүхдийн дэргэд хэрүүл хийхийг цээрлэнэ. Эс хэрэгсвээс хэрүүлийн бузар болж, өвдөж зовно. *Угтаа хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлэх, айл гэрийн амгалан тайван байдлыг алдагдуулахгүй гэснийх болно.*

<sup>9</sup> З.Фройд. Онгон шүтлэг ба хорио цээр. УБ. 2009

3. Ингэж далдын хүч нөлөө, өвчин зовлонгоос айх айдас дээр нь тулгуурлах нь хэрүүл хийх нь тийм сайн зүйл биш гэж сургаснаас илүү үр дүнтэй арга юм. Ямар ч эцэг эх үр хүүхдээ өвчин зовлонд унагахыг хүсдэггүй.

4. Нялх хүүхдийн хувцас, манцуйг гадаа хонуулахыг цээрлэнэ. Эс цээрлэвээс муу юм шүглэнэ, чөтгөр эзлэнэ гэнэ. Чухамдаа чийг дааж, жавар хоргоно гэхийн учир цээрлэдэг.

5. Аяганы амсар эмтэрхий бол алив хүнд цай унд хийж барихыг цээрлэнэ. Хэрэв тийн үйлдвээс үл хүндэтгэсэн болно. Эрт үедээ хүн нас барахад түүний эдэлж хэрэглэж байсан зүйлсийг хамт хийхийн зэрэгцээ ингэхдээ эмтэлж хийдэг байснаас үүдсэн цээр болой.

6. Аяга шаазангаа хүүхэд багачуул толгой дээрээ хөмөрч наадахыг цээрлэнэ. Хөмөрч наадвал Тэнгэр гандааж тариа будаа идэхгүйн ёр хэмээдэг. Хүүхэд багачууд аягаа унагааж хагалж бэртэх, идэж уудаг эд хогшилоороо тоглох буруу зурилыг арилгах гэснээс үүдэлтэй хорио.

7. Аяга даалингаа бусдад өгч хэрэглүүлэхийг цээрлэнэ. Хишиг буянаа дундлахгүй гэх учир болой. Өөрийн өвчин бохирдлыг бусдад, бусдын өвчин бузрыг өөрт халдаахгүйг эрхэмлэдэг ёс заншилтай холбоотой бөлгөө.

8. Бул чулууны нүхээр шагайхыг цээрлэнэ. Чөтгөр нүүрлэнэ. Чухамдаа ан амьтан, могой нүүр нүд гэмтээхээс сэрэмжилж буй хэрэг.

9. Үлдээсэн хоолыг ил задгай тавихыг цээрлэнэ. Заавал бүтээх буюу таг тавьж хонуулна. Эс хэрэгсвээс чөтгөр долооно

гэнэ. Чухамдаа тоос шороо, хорхой шавьж орохоос сэрэмжилж буй хэрэг бөлгөө.

Дээрхи хорио цээрүүдийн тайлбар нь хүнд айдас үүсгэх замаар тухайн гаж буруу зуршлыг засах, аливаа сөрөг үр дагавараас өөрийгөө болон бусдыг хамгаалах, байгаль дэлхийгээ хайрлах, ардын бэлгэдэл, ёс журмыг мэддэг, хүндэлдэг, эрхэмлэдэг болгоход онцгой үр дүнтэй сэтгэлзүйн өвөрмөц арга болох нь харагдаж байна. Зөвхөн жишээ авсан эдгээр хорио цээрүүдийг харахад л дан ганц шинжлэх ухааны үүднээс тайлбар өгөхөд хангалтгүй хорио цээрүүд олон байгаа бөгөөд шинжлэх ухаанч тайлбар өгсөөр байтал уг хоригийг зөрчих тохиолдол олон гарч болох юм.

Тухайлбал, өнөө үед шинжлэх ухааны дэвшилтэй уялдуулан хүүхэд багачууд төдийгүй насанд хүрэгчид гар утас, зурагт, интернет тоглоом зэргийг ихээр ашиглах (тоглох, танин мэдэхүйн мэдээлэл авах, мэдээлэл социлцох) болсон бөгөөд шинжлэх ухааны үүднээс бол эдгээрийг хэт хэрэглэх нь хүний биед муу нөлөөтэй, улмаар хүүхэд багачууд донтох, сэтгэцийн өвчтэй болох аюултай хэмээн зөвлөөд, батлаад байхад, тэр бүх тайлбарыг сонсоод мэдээд байгаа хэрнээ хол байх нь бүү хэл хэрэглээ нь улам ихсээд байгаа тал ажиглагдана. Харин хорио цээрийн ёсны үүднээс бодоод үзвэл хүний айдас дээр нь тулгуурлан зөв цагтаа, зөв хориог гаргаж чадвал эерэг үр дүнтэй байж болох юм.

Өнөө үед ч бид бүгд зарим нэг хорио цээрийн шинжлэх ухааны тайлбарыг мэдэх хэрнээ айдас, итгэл бишрэл дээр нь тулгуурласан тайлбарыг илүүтэй хэрэглэж,

түүндээ итгэдэг. Энэ нь тухайн хорио цээрийг зөрчихгүй байхаас өөр аргагүй тайлбар болдог. Тухайлбал: Хутганы ирийг дээш нь харуулж тавьдаггүй. Хэрүүл гарна гэх буюу гараа эсгэхээс сэрэмжлүүлэх, Ширээн дээр суудаггүй, өрөнд орно, аяга халбага угсруулж тавьдаггүй ажил бүтдэггүй гэх буюу ёс суртахууны хүмүүжилд хандсан цээрүүд нь хүний айдас, үгийн хийгээд үйл хөдлөлийн ид шидэнд итгэх итгэл, шашны ойлголт дээр тулгуурласан байгаа бөгөөд үр дүн нь шинжлэх ухаанч тайлбар өгснөөс илүү байгаа нь ажиглагддаг. Түүнчлэн зарим хорио цээрийг мухар сүсэг хэмээн үзэх хандлага ажиглагдаж байгаа нь тухайн хорио цээр ахуйтайгаа зөрчилдсөний илрэл юм. Жишээ нь: Босоогоороо цай уудаггүй. Үнээ босоогоороо тугална, Эмэгтэй хүн үсээ задгай тавьдаггүй, муу ёр зэрэг хорио цээрүүд нь өнөө үеийн ахуйтай зөрчилдөж байна. Босоогоороо цай уух нь яаруу сандруу хүний шинж хэмээн үздэг байсан бол өнөө үед босоо хүлээн авалт, тоглолт хийх болж, Үсээ задгай тавих нь бэлбэсэрсэн эмэгтэй гашуудах хугацаандаа үсээ задгай тавьдаг байсан бол өнөө үеийн хүүхэд залуус, эрэгтэй эмэгтэй гэлтгүй үсээ ургуулж задгай тавьдаг болжээ. Энэ нь тухайн хорио цээр үүссэн ахуй өөрчлөгдөж анх байсан үүрэг, ач холбогдлоо алдсаны улмаас өнөө үеийн хүмүүст мухар сүсэг хэмээгдэж байгаа юм.

Иймд бүх зүйл тэр дундаа хүний аюулгүй, ёс суртахуунтай амьдрах орчин, нөхцөл бололцоог бий болгоход шинжлэх ухаанч байдлаас гадна сэтгэлзүйн ойлголт болох айдас, итгэл үнэмшлийг зөвөөр

ашиглах нь үр дүнтэй болох талтай.

Ерөнхийлөн дүгнэж хэлэхэд, хорио цээр гэдэг бол хэдийгээр хүний айдас дээр тулгуурлан эцэг өвгөдөөс үр хойчдоо захиж хэлсэн үг боловч гол зорилго нь хүмүүсийг, ялангуяа хүүхэд залуучуудыг ёс суртахуунтай, хүнлэг энэрэнгүй сэтгэлтэй болгох, болзошгүй аюулаас сэрэмжлэх, ариун нандин зүйлийг уламжлан хөгжүүлэхэд чиглэгдсэн хүн төрөлхтөний мэдлэг ухааны нэгэн өвөрмөц төрөл юм. Түүний зэрэгцээгээр монголчуудын хорио цээрийн ёсонд Буддын “нүгэл” хэмээх ойлголт нэвтэрснээр Буддын учир шалтгааны үүднээс гаргаж ирсэн муу үйлийн үр дагаврын тухай ойлголтыг зан заншил болгож хэвшүүлэх үйл явц уламжлал болжээ.

## НОМ ЗҮЙ

1. Арьяасүрэн Ч, Нямбуу Х. 1992. Монгол ёс заншлын их тайлбар толь. УБ., 926.
2. Арьяасүрэн Ч, Нямбуу Х. 1992. Монгол ёс заншлын дунд тайлбар толь. УБ., 381
3. Амархүү О. Байгаль орчныг хамгаалах Монгол зан заншил, хууль цааз. УБ., 2001.
4. Бор Б., Нямаа Б. Сурган хүмүүжүүлэх зүйн зарим асуудал. УБ., 1996.
5. Дашдаваа Ж. Монголын уламжлалт гэрийн хүмүүжил. УБ., 2010.
6. Нацагдорж Ц, Нямбуу Х. Монголчуудын цээрлэх ёсны хураангуй толь. УБ., 1993
7. Нацагдорж Ш нар. Монголчуудын байгаль хамгаалдаг уламжлалт ёс



- заншил, зан үйл. УБ., 2007. 130
8. Одбагмэд З. Монгол ардын хүндлэх мэндлэх, талархах, зэмлэх, хориглох цээрлэх ёсон. УБ., 2004
9. Өлзийсайхан Ж. Ардын сурган хүмүүжүүлэх зүйн зарим асуудал. УБ., 2001, 130
10. Соном нар.1991.Монгол цээрийн ёсон. ӨМИС хэвлэлийн хороо,207
11. Түдэв Л.2000.Монгол ёсон.УБ.,524
12. Фройд З.2009.Онгон шүтлэг ба хорио цээр.УБ.,151
- 13.Цэвэл Я.1966.Монгол хэлний товч тайлбар толь.УБ.,911
- 14.Цэндээхүү Ц.2001.Монголчуудын байгаль хамгаалах ёс заншил, уламжлалаас.УБ.,164

### ABSTRACT

#### TABOO – FEAR- SIN

In this article, we consider that prohibitions are trying to forbid human wrong actions through frightening them by mostly religious supernatural force but not through scientific explanation. In truth, much time we need to take immediately measures to protect our safety without any explanations.

In this case prohibitions are most convenient customs that traditionally conformed by ancestors. The word “bad karma” penetrated in Mongolian prohibitions to be afraid from it since Buddhism spread within Mongolian people. Although by the Buddhist doctrine any bad action has bad result in after death life, Mongolian prohibitions explain there is really the mysterious negative impact.

So we consider the word “bad karma” in Mongolian prohibitions means a frightful result.